

## **СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2013 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

### **Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:**

**1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:**

**2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:**

Аймгийн Засаг даргын Тамгын газраас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээг 2013 оны 9 дүгээр сарын 16-ны өдрөөс нийт сум, тосгодод зохион байгуулж эхлэн, төрийн үйлчилгээг түргэн шуурхай, газар дээр нь иргэдэд нэг цэгээс хүргэж, аймгийн Нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын баг ажиллаж алслагдсан сум, тосгодын иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлдэгээрээ онцлогтой.

Аймгийн Засаг даргын Тамгын газраас сумын Засаг даргын Тамгын газар, орон нутагт төрийн үйлчилгээг үзүүлдэг төр төсвийн байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийн, төрийн албан хаагчдын чадавхийг сайжруулж, орон нутгийн төрийн албан хаагчдын мэдлэг чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Баруунбүрэн суманд “Шалган туслах” ажлын хэсгийг ажиллууллаа.

- Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан “Улсын бүртгэлийн үйл ажиллагаа орон нутагт” Зүүнбүеийн 6 аймаг оролцсон сургалтыг хамтран зохион байгуулсан
- “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээнд оролцож Шаамар, Хүдэр, Бугант, Дулаанхан тосгодод ажилласан.

### **Хоёр.Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:**

**1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:**

07-р сарын 31-ний байдлаар

/мянган төгрөгөөр/

д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Орон нутгийн төсвийн орлого			
2	Үүнээс: Аймгийн төсвийн орлого			
3	Орон нутгийн төсвийн зарлага			
	Үүнээс: Аймгийн төсвийн зарлага			
	Аймгийн ОНХСангийн зарцуулалт			
	Авто замын хөрөнгө оруулалт			
4	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт			
5	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг			
6	Засаг даргын нөөц			

2013 оны төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр орон нутгийн төсвийн орлого 91.8 хувь, улсаас авах санхүүгийн дэмжлэг 100.0 хувь, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 70.7 хувь, салбарын байгууллагуудын тусгай зориулалтын

шилжүүлэг 100.0 хувь тус тус биелэгдсэн байна. Төсвийн зарлагын гүйцэтгэл 91.9 хувийн биелэлттэй, сумдын санхүүгийн дэмжлэг 100.0 хувь, Засаг даргаас олгох нөөц хөрөнгийн гүйцэтгэл 127.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

**2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:**

№	Барааны нэр, төрөл	Хэмжих нэгж	Үнэ, ханш /төгрөгөөр/	
			2012 оны 7-р сар	2013 оны 8-р сар
Нэг.Талх, гурил, будаа				
1	Гурил /1-гурил/	1 кг		
2	Талх /орон нутгийн/ том, жижиг	ш		
3	Нарийн боов	1 кг		
4	Элсэн чихэр	1 кг		
5	Цагаан будаа	1 кг		
Хоёр.Мах, махан бүтээгдэхүүн				
6	Хонины мах	1 кг		
7	Үхрийн мах	1 кг		
8	Адууны мах	1 кг		
9	Ямааны мах	1 кг		
10	Дотор мах цувдай	1 кг		
11	Хиам, чанасан	1 кг		
12	Гахайн мах	1кг		
Гурав.Сүүн бүтээгдэхүүн				
12	Сүү /задгай/	1л		
13	Сүү /савласан/	1л		
14	Тараг /задгай/	1л		
15	Хорхой ааруул	1 кг		
16	Айраг	1л		
17	Хуурай сүү /орос/	1 кг		
18	Өндөг	ш		
Дөрөв. Бүх төрлийн өөх тос				
19	Ургамлын тос	1 кг		
20	Өөхөн тос	1 кг		
21	Шар тос	1 кг		
22	Масло /задгай/	1 кг		
Тав.Хүнсний ногоо				
23	Төмс/Монгол/	1 кг		
24	Лууван	1 кг		
25	Манжин	1 кг		
26	Байцаа	1 кг		
27	Сонгино	1 кг		
28	Өргөст хэмх /Монгол/	1 кг		
29	Тарвас /Монгол/	1 кг		
30	Өргөст хэмх /даршилсан/	ш		
31	Алаг салат	ш		

	/даршилсан/			
Зургаа.Тээвэр шатахуун				
32	Бензин А-80	1 л	1540	1540
33	Бензин А-92	1 л	1650	1650
34	Дизель түлш	1 л	1780	1780

### Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

#### 1.Архивын талаар:

- Архивын ерөнхий газраас ирүүлсэн албан бичгийн дагуу мэргэшүүлэх сургалтанд хамрагдахаар ирүүлсэн захиалга өгсөн ажилтануудаа сургалтанд оролцуулах тухай холбогдох 4 байгууллагуудад мэдэгдэж албан бичиг хүргүүлсэн.
- Архивын тасгийн 2013 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Архив, албан хэрэг хөтлөлт, байгууллагын архивын ORG-AMS программын талаархи бүсчилсэн сургууль зохион байгуулах ажлын хүрээнд 09 сарын 5-6-ны өдрүүдэд Хушаат, Зүүнбүрэн, Мандал, Түшиг, Цагааннуур, Баянгол сум, Түнхэл тосгоны төр, төсвийн байгууллагуудын 11архив, бичиг хэргийн эрхлэгч нарт “Архив, албан хэрэг хөтлөлт”, байгууллагын архивын ORG-AMS программыг ашиглах талаар онолын хичээлийг дадлага ажилтай хавсран заасан. Мөн байгууллагын архивын ORG-AMS программыг 6 сумдын компьютерт шинээр суулгаж мэдээллийн аюулгүй байдлыг хангах үүднээс бүх компьютерт вирусын программ болон Photoshop программ суулгасан.
- Аймгийн Усны аж ахуйн удирдах газрын 1970-1991 оны 97 хадгаламжийн нэгжид нягтлан шалгалтын ажлыг хийж, тоон хэлбэрт шилжүүлэх баримт, сэлбэн засалтын судалгаа, устгах бичгийн жагсаалтыг гаргаж дансны дахин боловсруулалт хийсэн. Мөн Цагаантолгой САА-н нөхөн бүрдүүлэлтээр ирсэн 16 хн-д нягтлан шалгалтын ажлыг хийж данс бүртгэлийг шинээр гаргасан.
- Төрийн архивын үйл ажиллагаанд ашиглаж байгаа AMS программд Түнхэл Мод бэлтгэлийн аж ахуйн 81 хн, Сант сумын АДХГЗ-ны 90 хн-ийн тухай мэдээллийг шивж оруулсан.
- Эрдэм шинжилгээ, мэдээлэл-лавлагаанд ихээр ашиглагддаг баримтанд ЭШТБ-ын ажлыг нийт 5 хөмрөгийн 115 ХН буюу 10334 хуудас бүхий баримтанд сканердан мастер хувь үүсгэж үдэж хавтаслан нүүрний бичилт бичиж хөмрөгт байрлуулсан.
- Мастер хувиас Photoshop программ ашиглан Алтанбулаг сангийн аж ахуйн 8 хн-ний 1324 хуудсанд ашиглалтын хувь үүсгэх ажлыг хийгээд байна.
- Орхонтуул сангийн аж ахуйн 13хн, Баруунхараа САА-н 50хн, Ус, цаг уур орчны шинжилгээний албаны 14 хн буюу нийт 77 хн-д сэлбэн засалтын ажлыг хийж хөмрөгт байрлууллаа.
- Иргэд, албан байгууллагын хүсэлтийн дагуу архивын хуулбар 71, архивын магадлагаа 24, тодорхойлолт 31-ийг гаргаж үйлчилсэн байна.

#### 2.Гэмт хэрэг, зөрчлийн талаар:

### Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

#### 1.Боловсролын чиглэлээр:

- 2.Эрүүл мэнд, биеийн тамирын чиглэлээр:
- 3.Нийгмийн даатгалын талаар:
4. Нийгмийн халамжийн үйлчилгээний талаар:
5. Хөдөлмөр эрхлэлтийн талаар:
- 6.Хүүхэд залуучуудын талаар:

**Тав.Хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:**

**Зургаа. Газрын харилцаа, Байгаль орчны бодлогын хүрээнд:**

- 1.Газрын харилцааны талаар:
- 2.Барилга хот байгуулалтын талаар:
- 3.Байгаль орчны талаар:
- 4.Тээвэр авто замын талаар:

**Долоо.Сүм орон нутгийн талаар:**

**1.Баруунбүрэн сум:**

Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын ЗДТГ нь газар тариалан, жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо, малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал, мал аж ахуйн үйлдвэрлэл технологийн чиглэлээр гарсан хууль тогтоомж, төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, тэдгээрийг иргэдэд таниулах, мал аж ахуй, газар тариалан, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх сонирхолыг бий болгож шаардлагатай мэдээллийг цаг алдалгүй хүргэх зорилтын хүрээнд дараахь ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Газар тариалан, мал аж ахуй, хоршоо, жижиг дунд үйлдвэртэй холбогдолтой шинээр гарсан хууль, дүрэм, журам, тогтоол шийдвэрүүдийг цаг тухай бүрт иргэдэд суртачлан таниулж ажилдаа мөрдлөг болгон ажиллаж, хадлан бэлчээр, тариалангийн талбайг хамгаалах тухай сумын Засаг даргын 2013 оны 5-р сарын 14-ний өдрийн А/38 тоот захирамжийг малчид, мал бүхий иргэдэд сурталчлан хөдөөгийн малчдаар 2 удаа явж гарын үсэг зуруулж ажиллаа. Мөн Орхон аймагт зохион байгуулагдсан мал аж ахуйг эрсдлээс урьдчилан хамгаалах сэдэвт сургалтанд хамрагдсан.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2013-2014 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай 08 тоот албан даалгавар, сумын Засаг даргын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлыг зохион байгуулах комисс томилох тухай сумын Засаг даргын А/70 тоот захирамжийг албан байгууллага, аж ахуйн нэгжид хүргүүлсэн. Мөн сумын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах арга хэмжээний төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Сумын Засаг даргын захирамжаар ургац тогтоох ажлын хэсэг томилон 2013 онд тариалсан аж ахуйн нэгж, иргэдийн талбай бүрээр ургац тогтоолтыг хийсэн. Ургац тогтоолтын дүнгээр 12853 га талбайд тариалснаас 1157 га талбай нь ургац тогтоох боломжгүй байсан учир 11696 га талбайн ургацыг тогтооход нэг га талбайгаас 15,7 цн буюу 18362 тонн үр тариа хураан авахаар урьдчилсан дүн гарсан.

Ургац хураалт, хадлан тариа бэлтгэх ажлыг шуурхай удирдлагаар хангах тухай штаб байгуулах тухай А/73 тоот захирамжийн дагуу ургац хураалтын мэдээ тайланг тухай бүр авч холбогдох газарт хүргүүлж байна. Сумын хэмжээнд ургац хураалт үр тариа 4000 га талбайг ангилж 1100 га талбайгаас 1150 тн үр тариа, 2500 га рапс ангилж 1200 га талбайгаас 1300 тн рапс хураан аваад байна. Мөн төмс хүнсний ногооны хураалтын явц 30%-тай байна.

Суманд үйл ажиллагаа явуулж байгаа хоршоодын судалгааг гаргаж аймгийн ХХААЖДҮГазарт хүргүүлсэн.

Аймгийн хэмжээнд адуунаас бусад бүх мал сүргийн төлийн вакцинжуулалтын ажил одоогийн байдлаар 94,5%-тай хийгдэж байна. Намрын угаалгыг шүршиж угаах аргаар 25 өрхийн 7700 толгой малд хийж, хээлтүүлэгч малын цусыг шинжилгээнд хамруулахаар аймгийн мал эмнэлгийн лабораторид хүргүүлээд байна.

Сумын санхүү төсвийн бодлого тодорхойлох, төлөвлөлт хийх, төсвийн ерөнхийлөн захирагч буюу Засаг даргын жил бүрийн төсвийн төсөл боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, төсвийн удирдлагын шинэчлэлийг хэрэгжүүлэх, хяналт тавих, төсөвт байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэсэн санхүүгийн болон мэргэжлийн зөвөлгөө арга зүйн дэмжлэг үзүүлж төсвийг хэмнэлттэй оновчтой, зориулалтын дагуу зарцуулах, төсвийн өр авлага үүсгэхгүй байх зорилт тавин ажиллаж байна

Төрийн санд 2013 оны 09 сарын гүйцэтгэлийн мэдээгээр орон нутгийн төсвийн орлогод 30003,1 мянган төгрөг оруулах төлөвлөгөөтэйгээс 35171,5 мянган төгрөг оруулж төлөвлөгөөний биелэлт 117,2 хувьтай байна.

Засгийн газраас хэрэгжүүлж байгаа ажлын хүрээнд тус суманд Гео тар ХХК нь геодезийн байнгын цэг тэмдэгт 3 ширхэгийг шинээр суулгаж түүнийг хүлээн авч акт үйлдэн холбогдох газарт хүргүүлсэн. Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд хадлан бэлтгэх мал бүхий иргэн, аж ахуйн нэгжид хадлангийн талбай хуваарилалтыг багийн Засаг дарга, байгаль орчны хяналтын улсын байцаагч, газрын даамал нар хамтран хуваарилан ажиллаж байна.. Мөн зөвшөөрөлгүйгээр газар ашигласан иргэн аж ахуйн нэгжид газар чөлөөлөх тухай мэдэгдэх хуудас, эзэмшлийн газраа зориулалтын дагуу ашиглаагүй, газрын төлбөрөө төлөөгүй иргэн аж ахуйн нэгжийн судалгаа гарган мэдэгдэх хуудас хүргүүлж ажиллаа.

Сэлэнгэ аймгийн Хөдөлмөрийн хэлтэст хөдөлмөр эрхлэлтийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ түүний үр дүн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хийсэн уулзалт зөвөлгөөнд оролцсон. Уулзалт зөвөлгөөнөөр 2011 оноос хойш олгосон сум хөгжүүлэх сангийн зээлийн хувийн хэрэг, сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн мэдээг гарган өгч, аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дэлгэрэнгүй судалгаа, тус суманд үйл ажиллагаа явуулж байгаа нөхөрлөл, хоршооны судалгааг Хөдөлмөрийн хэлтэст хүргүүлэн ажиллаа.

Хуурайшилтын үе эхэлсэнтэй холбогдуулан ойн болон тал хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, Байгаль орчныг хамгаалах тухай болон, ойн тухай хуулийн сурталчилгааг 119 иргэнд танилцуулж сурталчлан ажиллахын зэрэгцээ ойн хамтын эзэмшлийн нөхөрлөлүүдэд ойн сангийн зурган дээр ажиллах, менежмент төлөвлөгөө боловсруулах аргачлал хийж гүйцэтгэх ажлыг нөхөрлөлийн ахлагч гишүүд нарт заан өгч сурталчлан ажиллаа. Аймгийн ИТХ-аас баталсан хуваарийн дагуу орон нутгаас бэлдэж байгаа ойн нөөцгүй сумдууд болон тус сумын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын түлшний болон хэрэглээний модны бэлтгэл, тээвэрлэлт, түлшний модны стандартын хэрэгжилтэнд хяналт тавин ажиллах явцад илэрсэн 18 иргэний зөрчлийг арилгуулан, 125 иргэнд зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн. Хариуцсан сумдуудаас хэрэглээний болон түлшний мод бэлтгэх эрхийн бичгийн захиалга авч аймгийн Байгаль орчны албаны мэргэжилтнээс захиалгын дагуу авч сумдуудад

хүсэлтийн дагуу олголт хийж ажиллаж байна. Ахуйн зориулалтаар хадлан өвс бэлдэж байгаа иргэн, аж ахуйн нэгжээс байгалийн ургамал ашигласны төлбөрт 500,0 төгрөгийг хураан авч төсөвт оруулж, гоожингийн орлого 3505400 төгрөгийг төрийн санд, улсын тэмдэгтийн хураамж, хуудасны үнэ 925600 төгрөгийг ойн ангийн дансанд тус тус оруулсан.

Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын ЕББДСургууль нь 2013-2014 оны хичээлийн жилд элсэн орох суралцагчдыг бүртгэн авч судалгааг БСГазарт хүргүүллээ. Мөн орхон бүсийн багш, удирдах ажилтны бага хурал, төрөлжсөн сургалтанд нийт 26 багш хамрагдсан. 2013-2014 оны хичээлийн шинэ жилийн нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулж урлаг спортын арга хэмжээг 2-11-р ангиудын нийт 160 суралцагч багш, эцэг эхчүүдийг харуулан зохион байгуулан ажиллаж, Монгол Улсын ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн “хуулийн засаглал хүүхдийн оролцоо” сэдэвтэй теле хичээлийг нийт сурагчдад сонсгож ажиллаа. Хуучин ном солилцох ба худалдаалах өдөрлөгийг 2013.09.10-ны өдөр дунд ахлах ангийн сурагчдыг хамруулан зохион явуулахад давхардсан тоогоор 306 сурагч, 34 багш, эцэг эхчүүд хамрагдлаа.

Сургуулийн өмнөх боловсролын хүрээнд 160 хүүхдийг ясли, бага, дунд, ахлах бэлтгэл гэсэн бүлгүүдэд хамруулан авч боловсролын газарт СӨБ-ийн багш, ажилчид, хүүхдүүдийн нэгдсэн судалгааг хүргүүлэв. Бэлтгэл А,Б, ахлах дунд бүлгийн 100 хүүхдийг цагаан хорхой, шээс, цусны шинжилгээнд хамрууллаа. Багш ажилчдыг мэргэжил дээшлүүлэх сургалт семинарт харуулан ажиллаж байна.

Албан бус боловсрол төв нь АДРА олон улсын байгууллагатай хамтран ажил мэргэжилгүй 30 залуусыг сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах, барилга засал чимэглэлийн чиглэлээр мэргэшүүлэх сургалтанд хамруулахаар судалгааг авч явууллаа. Амарбаясгалант хийдийн хүүхдүүдэд дүйцсэн хөтөлбөрийн сургалтыг 9-р сарын 10-наас эхлэн явуулж, хийдийн лам суралцагчдын дунд эрүүл мэндийн үзлэгийг багийн эмчтэй хамтран хийж, хувийн ариун цэвэр, халдварт өвчнөөс хэрхэн сэргийлэх талаар сургалт явууж гүйлтийн тэмцээн явуулж, чөлөөт цагаар нь цаасан урлал, даамны дугуйлан хичээллүүлж байна. Амарбаясгалант хийдийн дотуур байранд сүсэгтэн олны хандиваар 400 гаруй номтой номын сантай болоод байна.

Соёлын төв Ахмадын хороотой хамтран 7 хоног бүрийн 3 дахь өдрийн 15-17 цагийн хооронд сургалт семинар зохион явуулах, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх талаар үйл ажиллагаа явуулж хэвшээд байна. Тус суманд бүжгийн дугуйлан хичээллэж нийт 40 хүүхэд суралцаж байна. Мөн хэлмэгсэдийн өдөрт зориулж ИТХ, Сургуулийн нийгэм, түүхийн багш нартай хамтран ахлах дунд ангийн сурагчдад лекц уншиж хэлэлцүүлэг хийлээ. Угийн бичиг хөтлөлтийн талаарх сургалтыг иргэдийн дунд явуулж ажиллаж байна.

Тус сумын Эрүүл Мэндийн төвийн их засварын ажил 80%-тай явагдаж байна. Энэ сард эрүүл мэндийн төв нь бүгд үзлэг 96, амбулаторын үзлэг 87, гэрийн идэвхитэй хяналтын үзлэг 9, жирэмсний хяналтанд байгаа 28, жирэмсний хяналтанд шинээр орсон 6, бүртгэгдсэн халдварт бус өвчлөл 69, осол гэмтлийн өвчлөл 8, 0-5 хүртлэх насны хүүхдийн суулгалт өвчин 7, 0-5 хүртлэх насны хүүхдийн амьсгалын замын өвчлөл 19, түргэн тусламжийн дуудлага бүгд 49, алсын дуудлага 10, осол гэмтлийн дуудлага 2, хам шинжийн оношлогоо 2 байна. Шинэ хичээлийн жил эхэлснээс хойш сургууль цэцэрлэгийн хүүхдүүдийн өвчлөл ихсэж суулгалт,

амьсгалын замын өвчлөл зонхилж байгаа бөгөөд тус төв нь шаардлагатай бүхий л арга хэмжээг авч ажиллаж байна.

**2.Баянгол сум:**

**3.Зүүнбүрэн сум:**

**4.Мандал:**

**5.Орхон:**

Тус сумын Засаг даргын Тамгын газар нь аймаг, сумын Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хbtөлбөр, аймаг сумын нийгэм эдийн засгийн хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан заалт зорилтуудын хэрэгжилтийг хангах хяналтын графикийн дагуу төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажилласан.

Монголын тулгар төрийн 2222 жил, Их монгол улс байгуулагдсаны 807 жил, тусгаар тогтнолын 102 жил, Ардын хувьсгалын 92 жилийн ойтой давхцан Сэлэнгэ аймгийн Орхон суманд Ерөнхий боловсролын сургууль үүсч бий болсны түүхт 60 жилийн ойгоо тэмдэглэн өнгөрүүлсэн. Ойн арга хэмжээнд үе үеийн ахмад багш ажилчид – 156, 1957-2012 оны төгсөлтийн нийт 1042 төгсөгчид оролцож, Сэлэнгэ аймгийн Засаг дарга С. Бүрэнбат, Боловсролын газрын дарга Д.Загдгочоо, НБХэлтэсийн боловсрол хариуцсан мэргэжилтэн н. Оюун, Орхон сумын Засаг дарга Г.Булганчимэг нар оролцож боловсролын салбарт шилдэг оюунлаг боловсон хүчнийг бэлтгэж билэг авьяас мэдлэг боловсролоо харамгүй зориулсан үе үеийн ахмад багш, ажилтан ажиллагсдыг БШУ яамны Боловсролын тэргүүний ажилтан, БШУ яамны Жуух бичиг, Аймгийн жуух, НБНХ медаль, Аймгийн 80 жилийн ойн медаль, Аймгийн хүндэт тэмдэгээр тус тус шагнаж урамшуулсан байна.

Ойн арга хэмжээг тохиолдуулан үндэсний бөхийн баридаан, үндэсний сурын хаваа, хурдан морины уралдаан, гар бөмбөг, шатар, теннис зэрэг тэмцээн уралдааныг амжилттай зохион байгуулсан.

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын овоот хороолол, 24-р цэцэрлэг, орон сууцны зарим барилга, элеватор, гангийн үйлдвэр, дэр бетоны үйлдвэр, хогийн цэг, жимстэй хороолол, цэвэрлэх байгууламж, түүний шүүх талбай, зэрэг газрууд нь Сэлэнгэ аймгийн Орхон сумын нутаг дэвсгэрт байрладаг.

Эдгээр газруудыг Сайхан сумын нутаг дэвсгэрт оруулах саналыг 2000 оноос хойш одоог хүртэлх хугацаанд удаа дараалан тавьж байгаатай холбогдуулан хилийн цэсийг тодотгох, өөрчлөх, тогтоохоор Орхон сумын нийт ард иргэдээс санал авах ажлыг зохион байгуулж төвийн болон хөдөөгийн багийн 217 өрхийг санал асуулгад хамрууллаа.

Тус санал асуулгаар Сайхан сумын нутаг дэвсгэрт шилжүүлж өгөхийг дэмжсэн 121 өрх буюу нийт өрхийн 55.7 хувь, дэмжихгүй гэсэн 96 өрх буюу санал асуулгад оролцсон өрхийн 44.2 хувийг эзэлсэн. Мөн дээрх газар нутгийг Сайхан суманд шилжүүлсэн тохиолдолд тус сумын газар нутгийн аль хэсгээс шилжүүлсэн хэмжээний газартай тэнцэх хэмжээний газрыг сумандаа шилжүүлж авах талаар санал асуулгыг авахад санал асуулгад оролцсон өрхийн 147 нь буюу 67.7 хувь нь Орхон сумын 1-р багийн нутаг Сайхны амны хил залгаа газар нутгаас, 33 өрх буюу 15.2 хувь нь Бэлэндалай багийн нутагтай хил залгаа Хөтөл нарсны хөндийгөөс газар авахаар саналаа өгсөн байна. Хилийн цэсийг тогтоох ажлын санал асуулгын дүнг аймгийн Газрын албаны ажлын хэсэгт хүлээлгэж өгсөн.





хүнсний ногооны үзэсгэлэн худалдаанд оролцох иргэдийн нэрсийг гаргаж аймгийн ХХААЖДҮ-ийн газар, Улаанбаатар хотын “Дүнжингарав” худалдааны төвд хүргүүлсэн.

Монгол мал үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, мал эрүүлжүүлэх арга хэмжээг эрчимжүүлэх зорилгоор сумын Засаг даргын 2013 оны А/177 тоот “Бруцеллёз өвчнөөс өдүй÷èèàí ñýðæééýõ тарилга, шинжилгээнд хамруулах тухай” захирамжийн дагуу ажлын хэсэг томилогдон вакцинжуулалтын арга хэмжээг зохион байгуулан 1550 толгой бод, 16200 толгой бог мал хамрагдаж 65 хувьтай байна. Вакцинжуулалтын явцын мэдээг 5 дахь өдөр бүр аймгийн Мал эмнэлгийн албанд мэдээлэн ажиллаж байна.

“Намрын ногоон өдрүүд-2013” нэгдсэн арга хэмжээний хүрээнд “Алтан намар-2013” шинэ ургацын төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний, “Эрүүл хүнс-2013” хүнсний бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа Улаанбаатар хотод зохион байгуулах болсонтой холбогдуулан төмс, хүнсний ногоо тариалдаг аж ахуй нэгж, иргэдэд мэдээлэл хүргэж үзэсгэлэн худалдаан оролцох иргэдийн нэрсийг хүргүүлж төмс, хүнсний ногоогоор “Мөнхцагаанханд” хоршооны 4 гишүүн, загас, загасан бүтээгдэхүүнээр “Түшээ гүний амт” хоршооны 2 гишүүн оролцож байна.

Монгол Улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй “Шилмэл мал-2013” улсын үзэсгэлэн худалдаанд тус суманд үйл ажиллагаа явуулдаг “Сэлэнгэ үржлийн цөм сүргийн аж ахуй оролцож “Орхон” үүлдрийн эм хонь алтан медаль хүртсэн.

Мàë үí í үёæéí 3-р улиралын мэдээг батлагдсан маягтын дагуу үнэн зөв гаргасан эсэхэд хяналт тавьж àèí æéí Мал эмнэлгийн албанд хүргүүлсэн.

**Газрын алба:** Тайлант сарын байдлаар сумын 2013 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу өмчлөхөөр хүсэлт гаргасан 18 иргэний хүсэлтийг хүлээн авч сумын Засаг даргын захирамж гаргуулан кадастрын зураг үйлдэн / Сод сүрвэй ХХК-аар хийлгүүлсэн /, акт гаргаж, хянан баталгааны дүгнэлт бичин аймгийн Үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн газарт хүргүүлэн ажиллалаа.

Сумын хэмжээнд 85 иргэнд 7243 га хадлангийн газрыг бизнесийн зориулалтаар ашиглуулахаар гэрээ байгуулж ургамал ашигласны болон аж ахуй эрхэлсний орлогын албан татварт 13748750 төгрөгийг оруулсан. Малчид мал бүхий 239 иргэн малын өвсний зориулалтаар 2551 га газрыг хадахаар гэрээ хийсэн байна. Одоогийн байдлаар хадлан бэлтгэлийн ажил 60 хувьтай явагдаж байна.

### **Байгаль орчны алба:**

Сэлэнгэ аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2013 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 06 тоот тогтоолоор Орхон сум 2013 онд хуваарьлагдсан хэрэглээний болон түлшний модны гэрээг хийж Сэлэнгэ аймгийн Сант сумын нутгаас 1000 м/куб түлшний мод, Баруунбүрэн сумаас түлшний зориулалтаар 900 м/куб, хэрэглээний зориулалтаар 400 м/куб модны гоожинг айл өрх албан байгууллагуудад олгож өвөлжилтийн бэлтгэлийг хангуулан ажиллаж байна.

Намрын тариа хураалт, хадлан бэлтгэх ажил эхэлсэнтэй холбогдуулан Мангирт, Баюудай, Мэргэн шувуут, Шар хөтөл, Дэргээч, Агьтын хошуу, Нарст гуу зэрэг газруудаар явж тариа хураалт, хадлан бэлтгэлийн ажилтай танилцаж, намрын хуурайшилт эхэлж буйтай холбогдуулан ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх мэдэгдлийг 15 хадлангийн бригадад тарааж ажиллалаа. Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2013 оны 08 тоот албан даалгаврын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Баюудай, Мангиртад намаржиж байгаа 16 малчин өрхөд тариа хураалт дуустал

өвөлжөө, намаржаанд буухгүй байх албан мэдэгдлийг өгөөд байна. Тус суманд газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Мангирттрейд ХК, Хос булаг ХХК, иргэн н.Эрдэнэхуягийн тариалангийн талбайд малаа оруулж хохирол учруулсан Орхон сумын Бэлэндалай 2-р багийн малчин Т.Ганзориг, Ч.Саранхүү, Л.Ням-Очир нарыг Газрын тухай хуулийн 63.1.8 дахь заалтыг үндэслэн тус бүр 768000 төгрөг, малчин Ц.Цогбаярт 384000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ тус тус авсан. Мөн Ойн тухай хууль тогтоомж зөрчсөн О.Пүрэвдоржийг Ойн тухай хуулийн 47.2.12 дэхь заалтын дагуу 576000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан. Ой цэвэрлэгээний журмаар 21 иргэнд 88 м3 улиасны гоожин олгож 146800 төгрөгийг орон нутгийн дансанд оруулсан.

### **Иргэний бүртгэлийн талаар:**

Тус сумаас 13 иргэн шилжин явж 5 иргэн шилжин ирсэн. Мөн 16 нас хүрч шинээр иргэний үнэмлэх авахаар 9 иргэн захиалга өгч бүртгүүлсэн. Огт бичиг баримтгүй 2 иргэн бүртгэлтэй байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын бүсчилсэн семинар Сэлэнгэ аймгийн Гүн нуур зусланд 3 өдөр зохион байгуулагдаж, улсын бүртгэлийн өнөөгийн байдал, цаашдын зорилго зорилт, бүртгэлтэй холбоотой асуудлаар сургалт зохион байгуулагдлаа.

### **Нийгмийн халамж :**

Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжийн олголт 9 сарын байдлаар:

- Тэтгэвэр тэтгэмж -65 иргэнд 6920.480₮
- Жирэмсэн эхийн тэтгэмж -53 иргэнд 2282450₮
- Онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмж -16 иргэнд 2100000₮
- НМТ -27 иргэнд 1527600₮ тус тус олгосон.

ОНОТХУ-нд сумын ядуурлаас гаргах зорилтот бүлгийн 2 өрхийн хамруулан “Буянт мал” төсөл боловсруулан 1000000₮ ийн санхүүжилтийг олгон өвөлжөө засаж сэлбэн 10 толгой эм ямаа худалдан авч өглөө.

**Нийгмийн даатгал:** Төсвийн байгууллага болон аж ахуй нэгжүүдээс НДШ-д 10500.0 мянган төгрөгийг тооцож нийгмийн даатгалын санд оруулсан. Мөн төсвийн байгууллага болон аж ахуй нэгжүүдээс 9-р сарын НДШ-ийн тайланг гаргуулан өр авлагыг тооцож нийгмийн даатгалын санд оруулж ажиллалаа.

НДШ-ийн сайн дурын даатгалд 20 иргэний 845.0 мянган төгрөг, ЭМД-д 15 иргэний 120,6 мянган төгрөгийг тус тус нийгмийн даатгалын санд оруулсан. Аймгаас 44100.0 сая төгрөгний санхүүжилтийг авч тэтгэвэр тэтгэмжийг хугацаанд нь олгосон.

- Ө/н-ны тэтгэвэрт-198 иргэний 40987,6 мян төг
- Т/а-ны тэтгэвэрт- 18 иргэний 2859,3 мян төг
- Т/д- ийн тэтгэвэрт-44 иргэний 6810,0
- Цэргийн тэтгэвэрт-3 иргэний 1290,1 мянган төгрөгийг тавьж олголоо.

Нөхөн даатгалын ажлын хүрээнд сумын хэмжээнд нийт 401 иргэний өргөдөлийг хүлээн авч жагсаалтыг үйлдэн аймгийн нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлсэн. явуулав.

## Нийгмийн бодлого хөдөлмөр эрхлэлтийн талаар:

Тус суманд төмс хүнсний ногоо, хүлэмжний аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Мөнхцагаанханд” хоршоо нь 2013 онд Сэлэнгэ аймгийн Ерөө сумын 8 хоршоотой нэгдэн “Баян сэлэнгэ өгөөж” дундын хоршоо байгуулан үйл ажиллагаагаа өргөжүүллээ. 2013 оны 9 сард хоршооныхоо үйл ажиллагааг сум орон нутгийн ард иргэдэд сурталчлан ургацынхаа дээжээр “Хүлэмжний ногоо” үзэсгэлэн худалдаа зохион байгуулж хүнсний ногоогоор 20 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн гаргаж худалдаалсан. Тус үзэсгэлэнг зохион байгуулахад сумын ЗДТГ, ИТХ, Адра олон улсын байгууллага дэмжлэг үзүүлсэн байна.

Тайлант сарын хугацаанд хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй иргэдээс газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Тэгш буудай” ХХК түр ажлын байранд-2 иргэн, байнгын ажлын байранд сумын ЭМТ-ийн багийн эмчээр 1 иргэн, ЕБС-д сонгон шалгаруулалтаар сургалтын менежер 1, Түүх нийгмийн ухааны багш 1, бага ангийн багш-1 тус тус зуучлагдан ажиллаж байна.

**Төсөв санхүү:** Тайлант сарын байдлаар орон нутгийн татварын орлого оны эхнээс төлөвлөгөө 30520,0 мянган төгрөг, гүйцэтгэл 29565,7 мянган төгрөг, биелэлт 96,8% 2013 оны 09-р сарын 20-ний байдлаар төлөвлөгөө 5428,0 мянган төгрөг, гүйцэтгэл 2662,7 мянган төгрөг, биелэлт 49,0% байна. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт санхүүжилтийн төлөвлөгөө 154615,6 мянган төгрөг, гүйцэтгэл 106733,6 мянган төгрөг, 63% биелэлттэй байна.

## Төсвийн байгууллагуудын ажлын талаар:

**Эрүүл мэндийн төв:** Њòì ùí òĵí àì ä ýĊĵĕ ì ýí äèéí òòñèàì æ ĵèè÷èèāýā òĵāýí ø óóĊòàè æèā òĵĊòýúì æòýé òĵĊāýō, ° â÷í ° ñ óĊüä÷èèàì ñýĊæèéýō, àĊà èĊāýāýä ýĊĵĕ ì ýí äèéí àí èì àñĊì è ì èā ò ñóĊæèò ñóĊòàè÷èèāā ñàéæĊóóèæ àæèèàæààéí à.

## Нэг. Удирдлага зохион байгуулалт

Эрүүл мэндийн сайдын 2012 оны 274 тоот тушаал дахь “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний алдаа, зөрчлийг бүртгэх, мэдээлэх” зааврын дагуу үзлэг хийж 3 алдаа зөрчлийг илрүүлэн бүртгэж Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтэст мэдээлсэн. Илэрсэн алдаа зөрчлийг цаашил анхааран хяналт тавьж ажиллаж байна.

## Хоёр. Хүний нөөцийн удирдлага

### Гурав. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ

ЭМШУИС-ийн Нүдний тэнхимийн эрхлэгч, Анагаах ухааны Доктор, Профессор Уранчимэг эмч Бэлэндалай багт нэг өдөр ажиллаж зорилтот бүлгийн 50 иргэнд нүдний үнэ төлбөргүй үзлэг хийв.

**Эмнэлгийн тусламж үйлчилгээ:** Нийт үзлэг 154 Үүнээс:

-Амбулаторийн үзлэг 67

-Урьдчилан сэргийлэх үзлэг 33

-Гэрийн идэвхитэй эргэлт 21

Нийт дуудлага 25. Үүнээс:

\*Алсын дуудлага- 11

\* Ойрын дуудлага -14

Жирэмсний хяналтад одоо байгаа 32 эх, шинээр жирэмсний хяналтанд орсон 7, эхний 3 сартайд 100%-тай жирэмсний үеийн болон төрөлтийн хүндрэлгүй 100% дээд шатны эмнэлэгт 3 эх эсэн мэнд амаржсан.

Ахмад настан 45, 0-5 насны 62 хүүхдийг гэрийн эргэлт хяналтанд хамруулж, товлолт вакцинд 100% хамруулсан.

Малчдын явуулын амбулатори сард 1 удаа эргэлт хяналт хийж, 26 иргэнийг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулж, зөвлөгөө өгч ажилласан. Эмийн бус эмчилгээгээр 10 иргэн үйлчлүүлсэн байна.

4 төрлийн шинжилгээ хийгдсэн байна. Цусны ерөнхий шинжилгээ-15, шээсний ерөнхий шинжилгээ-18 , цагаан хорхой илрүүлэх шинжилгээ- 60 , цусны бүлэг тодорхойлох шинжилгээ-5 байна.

#### **ЕБС:Стандарт хангалт, сургалтын чанарыг ахиулах талаар:**

2013-2014 оны хичээлийн жилд нийт 263 суралцагч, 35 багш, ажилчидтай сургуулийн үйл ажиллагааг стандартын дагуу хэвийн явуулж байна. 1-р ангид 28 суралцагч элсэн орсон. Бага ангийн суралцагчид 100% сурах бичгээр хангагдсан. Мэргэжлийн бүх багш нар 1-11-р ангийн 1-р улирлын хичээлийн төлөвлөгөөг боловсруулж, төлөвлөгөөний дагуу хичээл сургалтаа явуулж байна.

Аймаг сумын Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан сургалтын стандарт хангалтыг хангуулах зорилтын хүрээнд 1-11-р ангийн сурагчдаас мэргэжлийн хичээлүүдээр түвшин тогтоох шалгалт авч, үр дүнг тооцон ажиллаж байна.

Багш нар сурагч нэг бүрийн хөгжлийг дэмжих, хөгжүүлэх зорилгоор сурагчдын түвшин, нас сэтгэхүйн онцлогт тохируулан жишиг даалгавар, ТӨМ , тест боловсруулсан байна. Үүнд:

Сургуулийн мэдээлэл зүйн кабинетад аймгийн засаг даргын хөрөнгө оруулалтаар 20 ш компьютертэй болж, сурагчдын сурч боловсрох орчин бүрдэн сургалтын үйл ажиллагаа явагдаж байна.

Сэлэнгэ аймгийн засаг даргын захирамжийн дагуу Нийгмийн ажилтан Б. Ганчимэг, Сургалтын менежер Г. Солонго нар 9-р сарын 17нд ахлах ангийн 56 суралцагчдын дунд СУРАГЧАА СОНСЪЁ нээлттэй хэлэлцүүлэг явуулан суралцагчдын санаа бодлыг сонссон.

Гэгээрэл төвийн “Ном” хөтөлбөрийн хүрээнд Боловсролын Газраас зохион байгуулагдсан төсөл шалгаруулах уралдаанд “Би ном унших дуртай” төслийг бичиж 50000 төгрөгийн төсөл авч АББ-ын Гэгээрэл төвийн номын санг баяжуулах боломжийг бүрдүүллээ. Мөн сургуулийн

түүхт 60 жилийн ойг угтсан ажилд Гэгээрэл төвд О.Болд, Ч.Эрдэнэчимэг нарын гэр бүлээс 1000000 төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, зургийн аппарат, 29 инчийн LCD телевизер Samsung 3050- принтер зэрэг сургалтын хэрэглэгдэхүүнийг хандивласнаар сургалтын таатай орчин бүрдсэн төдийгүй 1982 оны төгсөгчдийн 108000 төгрөгийн тусламжтайгаар сургалтын танхимд хөшиг, толь, өлгүүр, хогийн шүүр, хөшиг тогтоогч, 10 литр будаг зэрэг материалуудыг авч Гэгээрэл төвийн сургалтын танхимын сурах таатай нээлттэй орчинг бий болголоо.

### **СӨБ:**

Орхон 12-р цэцэрлэг нь 2013 оны 09-р сарын 01-нээс 20-нийг хүртэлх хугацаанд Бэлтгэл бүлэг – 30, дунд бүлэг -26, бага бүлэг -22 нийт 78 хүүхэд хүлээн авч үйл ажиллагаагаа явуулж байна. 2013 оны 08-р сарын 20-ноос 09-р сарын 20-ний хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

- Бэлэндалай багийн цэцэрлэгт 08-р сарын 30-н хүртэл 13 хүүхэд хүлээн авч сургалтын үйл ажиллагаа явууллаа.
- Сэлэнгэ аймгийн БСГазраас 2013 оны 08-р сарын 28-нд Сайхан суманд зохион явуулсан “ Хүүхэд нэг бүрийн хөгжил – Боловсролын чанар “ сэдэвт нэг өдрийн сургалтанд эрхлэгч З.Туяацэцэг, багш Д.Оюундалай, Д.Үржинням, Г.Үүрийнцолмон нар хамрагдав.

**Соёлын төв:** Соёлын төвөөс сумын нийт иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, соёлын үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэж төр засгийн бодлого шийдвэр, хууль тогтоомж, үндэсний хөтөлбөрүүдийг сурталчлан хэрэгжүүлэх, хүүхэд залуучуудын авьяас билгийг нээн илрүүлж хөгжүүлэхэд зорилгыг хэрэгжүүлж ажиллалаа.

Номын сан нь уншигчдад ном хэвлэл, мэдээ мэдээллийг өдөр тутам тогтмол хүргэж үйлчилснээр 25 уншигч, 223 ирэгсэд буюу нийт 248 уншигчдад 436 ном хэвлэлийг уншлагын танхим болон гэрээр олгож үйлчиллээ.

Номын санд өөрийн биеэр ирж үйлчлүүлэх боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настан, эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй 2 хүүхэд, 5 -н насанд хүрэгчдэд зөөврийн номын сангаар үйлчилж 32 ном, хэвлэл олголоо. Мөн хөдөөгийн багийн иргэдэд ном хэвлэлээр үйлчлэх ажлыг идэвхтэн уншигч Д.Дарьсүрэнтэй хамтран зохион явуулснаар 20 гаруй номтой зөөврийн номын санг Бэлэндалай, 42-р хэсгүүдэд ажиллуулж 13 уншигчдад 18 ном гэрээр олгоод байна.

### **Соёл хүмүүжлийн ажлын талаар:**

Хүүхэд багачуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, өөрийгөө хөгжүүлж мэдлэг чадвараа дээшлүүлэх, сэтгэхүйгээ хөгжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэн ажилласнаар англи хэлний цахим сургалтанд 8 хүүхэд, шатраар 5 хүүхэд тус тус бие даан суралцсан байна.

“Шинэ номын үзэсгэлэн”-г 2 удаа шинэчлэн гаргаж , мэдээллийн самбар ажиллуулснаар 248 уншигчдад мэдээлэл хүргэлээ. Намрын улирал эхэлж иргэд тариа, ногоогоо хурааж байгаатай уялдуулан жимс жимсгэнэ, төмс хүнсний ногоогоо хадгалах, боловсруулах талаарх ном , хэвлэлээр “Алтан намар-Арвин ургац ” сэдэвчилсэн үзэсгэлэн гаргаж , уншигчдад хэрэгцээтэй ном хэвлэл, мэдээ мэдээллийг гэрээр олгох, хуулбарлан хүргэх ажлын зохион байгуулан ажилласнаар 6-н уншигчдад 15 хэвлэлийн хуудас бүхий мэдээлэл олголоо.

Бага ангийн сурагчдыг номтой нөхөрлүүлэх, ном унших сонирхлыг төрүүлэх зорилгоор “ Үнсгэлжин” , “ Цасан охин ба 7-н одой” зэрэг үлгэрээр чанга уншлага хийж ,үлгэрийн ярилцлага зохион явуулав. Мөн бага ангийн сурагчдын хичээлээс гадуур унших номын жагсаалт, залуу хүн бүрийн заавал унших номын жагсаалт зэргийг гаргаж мэдээллийн самбарт тавьж сурталчилж байна.

## **6.Орхонтуул сум:**

Энэ онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлууд батлагдсан төлөвлөгөөний дагуу хийгдэж байгаа бөгөөд тус суманд ундны усны нийт 6 худаг гаргахаас одоогийн байдлаар Шар-Ус 1-р баг Рашаант тосгоны төвд 1, Баянцогт 2-р багийн төвд 2 худаг гаргасан ба малчдад зориулан шинээр 2 худаг гаргах юм.Мөн ОНХ сангийн хөрөнгөөр Рашаант тосгонд Эрүүл мэндийн төвийн халаалтын тогоо суурьлуулах ажил хийгдэж төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээг зохион байгуулах, хяналт тавих, ажлын гүйцэтгэлийг хүлээж авах ажлын хэсэг шалган хүлээж авлаа. ОНХ сангийн хөрөнгөөр Рашаант тосгонд Ахуйн үйлчилгээ төсөл хэрэгжиж барилгын ажил эхлээд байна.

Сэлэнгэ аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн санхүүжилтээр Нийтийг хамарсан ажлын хүрээнд 4140,0 сая төгрөгийн өртөг бүхий зам засварын ажил хийгдэж дууслаа. Энэхүү зам засварын ажилд ажил хөдөлмөр эрхэлдэггүй сумын Хөдөлмөр эрхлэлтийн албанд ажил идэвхтэй хайгчийн бүртгэлд бүртгэлтэй 30 хүнийг өдрийн 9900 төгрөгөөр 14 хоног ажиллуулсан байна.

Сумын Засаг даргын өвөлжилтийн бэлтгэл хангуулах захирамжийн дагуу өөр аймаг сумдаас ирж зусаж, намаржиж буй айл өрхүүдэд татвар төлбөр тооцоо барагдуулах, хадлан бэлтгэл, тариа хураалтын байдалд хяналт тавих зорилгоор татварын улсын байцаагч, ХААН тасгийн дарга, хэвлэл мэдээллийн ажилтантай хамтран хяналт шалгалт хийж сумын өвсний фонд бэлтгэлийн ажилд хяналт тавьж хадлан бэлтгэж буй иргэн аж ахуйн нэгжээс тус бүр 50 боодол өвс бэлтгүүлэн сумын фондод одоогоор 750 тонн өвсний нөөц бүрдүүлээд байна.

Энэ сард иргэдээс нийт 7 өргөдөл, хүсэлт хүлээн авсан бөгөөд үүнээс сургалтын төлбөрийн дэмжлэг хүссэн-2, ажил хүссэн-2, мал бүхий иргэний шилжин суурьших, бэлчээр нутгийн маргаан шийдвэрлүүлэхталаар хүсэлт-2,сумын Эрүүл мэндийн төвийн их эмчийн байрны түрээсийн дэмжлэг туслалцаа хүссэн-1 өргөдөл тус тус ирсэн байна. Иргэдээс ирүүлсэн өргөдөл хүсэлтийг тухай бүр сумын Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж хариуг эзэнд нь бичгээр хүргүүлж байна.

Сумын Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд сумын ИТХТ-н 2013 оны 20 тоот тогтоолоор батлагдсан “Шинэ төрсөн хүүхэд, эхчүүдэд хүндэтгэл үзүүлэх журам”-ыг тогтмолжуулан 25 хүүхдэд батламж, гарын бэлэг өгөх ажлыг зохион байгуулаад байна.

Тайлант сард сумын хэмжээнд шинээр төрөлт 10 бүртгэгдсэнээс эр-5, эм-5 хүүхэд байна. Гэрлэлт 2, үрчлэлт-4, нас баралт-1, эцэг тогтоолт-1 бүртгэгдсэн байна. Иргэдийн шилжилт хөдөлгөөнийг тухай бүр хийж шилжиж ирсэн иргэн-11, шилжиж явсан-12 иргэн байна. Малчин өрхийг жижиг дунд үйлдвэр эрхлэгчээр 41 иргэнийг бүртгэж Улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлэн гэрчилгээжүүлэх ажлыг хийгээд байна.

1997-2011 онд төрсөн төрөлтийн бүртгэл нь үндсэн мэдээллийн санд ороогүй зөрчилтэй 5 хүүхдийн зөрчлийг арилгаж нөхөн бүртгэл хийлээ.

